



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 11 өдөр

Дугаар А/559

Есөнбулаг

Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын
сургуулийн номын сангийн үйл ажиллагаанд
дэмжлэг үзүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалт, 56 дугаар зүйлийн 56.1 дэх хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 10, 11 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2023 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 35 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2.2.7, Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.8 дахь заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хүүхдийн сурч, хөгжих боломжийг нэмэгдүүлэх зорилгоор Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын сургуулийн номын сангийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дэмжлэгт шаардагдах 3,000,000 (гурван сая) төгрөгийг аймгийн Засаг даргын хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Э.Пүрэвжав)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

